



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 35 (368)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Монгол Улсын Ерөнхийлөгч Үндсэн хууль зөрчсөн тухай асуудлыг хянан шийдвэрлүүлэх тухай*
- *Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2004 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног дутмын

Улаанбаатар хот

2004 оны есдүгээр сарын 13

№ 35 (368)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- | | | |
|------|--|-----|
| 352. | Техникийн хамтын ажиллагааны тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай | 694 |
| 353. | Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 694 |

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- | | | | |
|------|--|-----------|-----|
| 354. | Монгол Улсын Ерөнхийлөгч Үндсэн хууль зөрчсөн тухай асуудлыг хянан шийдвэрлүүлэх тухай | Дугаар 35 | 694 |
| 355. | Ж. Бямбадоржийг Улсын Их Хурлын дэд даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай | Дугаар 36 | 694 |
| 356. | Ж. Бямбадоржийг Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай | Дугаар 37 | 695 |
| 357. | Н. Чинбатыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай | Дугаар 38 | 695 |
| 358. | Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох тухай | Дугаар 39 | 695 |
| 359. | Монгол Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай | Дугаар 11 | 696 |
| 360. | Ерөнхийлөгчийн хоригийн тухай | Дугаар 12 | 696 |
| 361. | Тогтоол хүчингүй болгох тухай | Дугаар 13 | 696 |



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 7 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

ТЕХНИКИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. БНМАУ-ын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газар хооронд 1992 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр байгуулсан Техникийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

/Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2004 оны 7 дугаар сарын 27-ны өдөр хориг тавьсан бөгөөд 2004 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр баталсан Техникийн хамтын ажиллагааны тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг хүчингүй болгох тухай хуулиар хүчингүй болгосон/

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 7 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3-ын "зургаан сарын" гэснийг "нэг жилийн" гэж өөрчилсүгэй.

/Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2004 оны 7 дугаар сарын 27-ны өдөр хориг тавьсан бөгөөд 2004 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр баталсан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болгох тухай хуулиар хүчингүй болгосон/

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 7 дугаар сарын 9-ний өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Ерөнхийлөгч Нацагийн Багабанди Монгол Улсын Үндсэн хуулийн хорин гуравдугаар зүйлийн 2, хорин долдугаар зүйлийн 6, далдугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус зөрчсөн асуудлыг хянан шийдвэрлүүлэхээр Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хандаж хүсэлт гаргах нь зүйтэй гэж үзсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч Үндсэн хууль зөрчсөн тухай асуудлыг хянан шийдвэрлүүлэх тухай
2.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

С.ТӨМӨР-ОЧИР

/Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2004 оны 7 дугаар сарын 27-ны өдөр хориг тавьсан бөгөөд 2004 оны 13 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 7 дугаар сарын 22-ны өдөр

Дугаар 36

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 4.4-т заасныг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Ж.Бямбадоржийг Улсын Их Хурлын дэд даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай
Улсын Их Хурлын дэд даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

1.Улсын Их Хурлын гишүүн Жамсрангийн Бямбадоржийг өөрийн нь хүсэлтийг үндэслэн

2.Энэ тогтоолыг 2004 оны 7 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.



**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

*/Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2004 оны
7 дугаар сарын 27-ны өдөр хориг тавьсан бөгөөд
2004 оны 13 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2004 оны 7 дугаар
сарын 22-ны өдөр**

Дугаар 37

**Улаанбаатар
хот**

**Ж.Бямбадоржийг Улсын Их Хурлын
гишүүнээс чөлөөлөх тухай**

Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 2-т заасныг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

2.Энэ тогтоолыг 2004 оны 7 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

*/Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2004 оны
7 дугаар сарын 27-ны өдөр хориг тавьсан бөгөөд
2004 оны 13 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/*

1.Улсын Их Хурлын гишүүн Жамсрангийн Бямбадоржийг өөрийн нь хүсэлтийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2004 оны 7 дугаар
сарын 22-ны өдөр**

Дугаар 38

**Улаанбаатар
хот**

**Н.Чинбатыг Үндсэн хуулийн цэцийн
гишүүнээс чөлөөлөх тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

2.Энэ тогтоолыг 2004 оны 7 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

1.Бүрэн эрхийн нь хугацаа дуусгавар болсон тул Намжилын Чинбатыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлсүгэй.

*/Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2004 оны
7 дугаар сарын 27-ны өдөр хориг тавьсан бөгөөд
2004 оны 13 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2004 оны 7 дугаар
сарын 22-ны өдөр**

Дугаар 39

**Улаанбаатар
хот**

**Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг
томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

2.Энэ тогтоолыг 2004 оны 7 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

1.Монгол Улсын Их Хурлын санал болгосноор Жамсрангийн Бямбадоржийг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилсугай.

*/Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2004 оны
7 дугаар сарын 27-ны өдөр хориг тавьсан бөгөөд
2004 оны 13 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/*



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай

2/ Раднаасүмбэрэлийн Гончигдорж
3/ Нямаагийн Энхболд

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хороог дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

1/ Ринчиннямын Амаржаргал

2. Энэ тогтсолыг 2004 оны 9 дүгээр сарын 6-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Н. ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Ерөнхийлөгчийн хоригийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 14.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Үндсэн хуульд заасан бүрэн эрхийнхээ дагуу Улсын Их Хурлын дөрөв дэх удаагийн сонгуулиар байгуулагдсан Улсын Их Хурлын анхдугаар чуулганыг товлон зарлаж, уг чуулганы ажиллагаа албан ёсоор эхэлсэн байхад өмнөх сонгуулиар байгуулагдсан Улсын Их Хурал 2004 оны 7 дугаар сарын 9-ний өдөр "Монгол Улсын Ерөнхийлөгч Үндсэн хууль зөрчсөн тухай асуудлыг хянан шийдвэрлүүлэх тухай" 35 дугаар тогтоол, мөн сарын 22-ны өдөр Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Техникийн хамтын ажиллагааны тухай БНМАУ-ын Засгийн

газар, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулиуд болон "Ж. Бямбадоржийг Улсын Их Хурлын дэд даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай" "Ж. Бямбадоржийг Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай" "Н. Чинбатыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай" "Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох тухай" 36, 37, 38, 39 дүгээр тогтоолд гаргасан нь Үндсэн хуулийн гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг, хорин долдугаар зүйлийн 4 дэх хэсэгт тус тус харшилсан гэж үзэж, 2004 оны 7 дугаар сарын 27-ны өдөр тавьсан хоригийг хүлээн зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Н. ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Тогтоол хүчингүй болгох тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 14.4-ийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Дор дурдсан Улсын Их Хурлын тогтоолуудыг хүчингүй болгосугай:

1/ "Монгол Улсын Ерөнхийлөгч Үндсэн хууль зөрчсөн тухай асуудлыг хянан шийдвэрлүүлэх тухай" 2004 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 35 дугаар тогтоол;

2/ "Ж. Бямбадоржийг Улсын Их Хурлын дэд даргын үүрэгт ажилаас чөлөөлөх тухай" 2004 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 36 дугаар тогтоол;

3/ "Ж. Бямбадоржийг Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай" 2004 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 37 дугаар тогтоол;

4/ "Н. Чинбатыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай" 2004 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 38 дугаар тогтоол;

5/ "Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох тухай" 2004 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 39 дүгээр тогтоол

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Н. ЭНХБАЯР

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргах.

"Төрийн Мэдээлэл" эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар- 12,

Төрийн ордон

☎ 329612

Индекс 14003

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын

Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487

Хэвлэлийн хуудас 0.5